



## МӨНГӨНИЙ ТОЙМ

2011 оны 4 дүгээр сар

### Инфляци

Жилийн инфляци Улаанбаатар хотод 4.2 хувь, улсын хэмжээнд 5.5 хувь байна. Улаанбаатар хотын сарын инфляци -0.5 хувь, улсын хэмжээнд -0.2 хувь гарлаа.

Сүүлийн саруудад инфляцийн бүтэц өөрчлөгдсөн байна. Махны үнэ өсдөг онцлогтой саруудад инфляци эсрэгээр буурлаа. Үүнд хэрэглээний сагсанд өндөр хувийн жин эзэлдэг махны үнийн түвшин өнгөрсөн оны мөн үед өндөр байснаас махны үнэ 10.4 хувиар буурсан нь нөлөөлжээ. Хэдийгээр ерөнхий индекс буурсан боловч бараа үйлчилгээний үнийн түвшин өндөр хэвээр байна. Хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ өсч байгаа нь тэдгээрийн инфляцид үзүүлэх нөлөөг нэмэгдүүлсээр байна. Тухайлбал, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн бараа, бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 13.5 хувь, согтууруулах ундаа, тамхиных 12.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 9.2 хувь, боловсролын үйлчилгээнийх 20.4 хувиар тус тус өссөн байна.



Улирлын хэлбэлзэл ихтэй, түр зуурын нөлөөлөлд автан хэт их хэлбэлздэг бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний сагснаас хасч “суурь инфляци”-ийг тооцов<sup>1</sup>. Суурь инфляци өмнөх сараас 1.3 хувь, өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өссөн байна. 2010 оны 1 дүгээр сараас хойш ерөнхий инфляциас илүү гарч байгаагүй суурь инфляци тайлант сард ерөнхий инфляциас 2 дахин өндөр гарчээ. Үүнд хэрэглээний сагсны бүх бүлгүүдийн үнийн тогтвортой өсөлт жигд байдлаар нөлөөлсөн бөгөөд тэр дундаас “хүнсний бүлэг”<sup>2</sup>, боловсролын үйчилгээ, хувцас, бөс бараа, гутлын бүлэг болон орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлт нь харьцангуй хүчтэй нөлөө үзүүлэв.


### Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт<sup>3</sup> өмнөх сараас 8.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 69.2 хувиар өсч 5350.5 тэрбум төгрөгт хүрчээ.

<sup>1</sup> Суурь инфляцийг мах, сүү, хүнсний ногоо хасч тооцов.

<sup>2</sup> Мах, сүү, хүнсний ногооноос бусад хүнсний бараа, бүтээгдэхүүн.

<sup>3</sup> M2-мөнгөний нийлүүлэлт нь бараг мөнгө, M1 мөнгөний нийлбэр.



2011 оны 4 дүгээр сарын байдлаар М2 мөнгөний жилийн өсөлтийн 45.7 хувийг төгрөгийн хадгаламж, 20.5 хувийг төгрөгийн харилцах, 11.4 хувийг гадаад валютын хадгаламж, 16.2 хувийг гадаад валютын харилцах, 6.2 хувийг банкнаас гадуурх мөнгө тус тус бүрдүүлжээ. Төгрөгийн хадгаламжийн нийт мөнгөний жилийн өсөлтөд үзүүлэх нөлөө өмнөх сарынхаас 3.0 нэгж хувиар, гадаад валютын хадгаламжийнх 0.8 нэгж хувиар тус тус буурч харин валютын харилцахынх 1.8 нэгж хувиар, банкнаас гадуурх мөнгөнийх 1.5 нэгж хувиар тус тус нэмэгдсэн байна.

### ***Хадгаламж***

Нийт хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 63.3 хувиар өсч 3222.8 тэрбум төгрөгт хүрэв. Нийт хадгаламжийн жилийн өсөлт 2011 оны эхний саруудад харьцангуй тогтвортой байв. Иргэдийн төгрөгийн хадгаламж өнгөрсөн оны мөн үеийнхээс 65.6 хувь буюу 829.3 тэрбум төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж 2.7 дахин буюу 170.4 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 40.9 хувь буюу 249.5 тэрбум төгрөгөөр тус тус өсөв. Нийт хадгаламжийн 73.3 хувь нь төгрөгийн, 26.7 хувь нь валютын хадгаламж бөгөөд төгрөгийн хадгаламжийн эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.2 нэгж хувиар нэмэгдсэн байна. Үүнд төгрөгийн ам.доллартай харьцах ханш өнгөрсөн оны мөн үеийнхээс 114 төгрөгөөр чангарсан нь тодорхой нөлөө үзүүлжээ.


### ***Нөөц мөнгө***

Нөөц мөнгө өмнөх оны мөн үеэс 56.0 хувь, өмнөх сараас 14.2 хувиар өсч 1163.8 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард нөөц мөнгөний бүрэлдэхүүн болох үзүүлэлтүүд өссөн байна. Банкуудын Төв банкин дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхээс 5.6 нэгж хувиар өсч 46.1 хувь болсон бол банкнаас гадуурх мөнгөнийх 4.7 нэгж хувиар буурч 40.8 хувь, банкуудын кассынх 0.8 нэгж хувиар буурч 13.1 хувьтай тэнцэж байна.

### Гадаад, дотоод цэвэр актив

Гадаад цэвэр актив өмнөх оны мөн үеийнхээс 76.9 хувиар өсч 2920.3 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив 60.7 хувиар өсч 2430.2 тэрбум төгрөгт хүрэв. Гадаад цэвэр активын жилийн өсөлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.4 нэгж хувиар буурч, харин сүүлийн саруудын хувьд тогвортой байв. Гадаад цэвэр активын дийлэнх хувийг эзэлдэг гадаад валютын цэвэр албан нөөц 2011 оны 4 дүгээр сард өмнөх сарынхаас 0.9 хувь буюу 18.5 сая ам.доллараар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 75.2 хувь буюу 911.7 сая ам.доллараар нэмэгдэж 2123.5 сая ам.доллар болов. Дотоод цэвэр активын жилийн өөрчлөлт 2010 оны эхнээс тогтвортой өсч байгаа бол гадаад цэвэр активын жилийн өөрчлөлт 2010 оны 11 дүгээр сар хүртэл эрчимтэй буурч, 2011 он гарснаас хойш харьцангуй тогтвортой байв.

Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл нийт мөнгөний 54.6 хувь нь гадаад цэвэр активт, 45.4 хувь нь дотоод цэвэр активт байршиж байв. Гадаад цэвэр активын M2 мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхээс 2.4 нэгж хувиар нэмэгджээ.



### Зээл


Хадгаламжийн байгууллагуудаас<sup>4</sup> олгосон зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.7 хувиар өсч 3973.9 тэрбум төгрөгт хүрчээ. Чанаргүй зээлийн хувь аажмаар буурч байгаа боловч энэ нь сүүлийн 2 сарын хувьд чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл буураагүй харин нийт зээлийн өрийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон нийт зээл өнгөрсөн оны мөн үеийнхээс 26.9 хувь буюу 474.6 тэрбум төгрөгөөр өсч 2240.5 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл 75.8 хувь буюу 737.0 тэрбум төгрөгөөр өсч 1709.3 тэрбум төгрөгт тус тус хүрчээ. Хувийн хэвшилд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлт өнгөрсөн оныхоос 18.0 нэгж хувь, **иргэдийнх**

<sup>4</sup> Хадгаламжийн байгууллагад банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.

**71.3 нэгж хувиар** өсчээ. Өнгөрсөн оны дунд үеэс эхлэн зээл олголт нэмэгдсэн бөгөөд дийлэнх нь иргэдэд олгосон байна. Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 56.4 хувь нь хувийн хэвшил, 43.0 хувь нь иргэд, 0.4 хувь нь улсын байгууллага, 0.2 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 88.3 хувийг хэвийн зээл, 2.1 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 9.6 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.4 нэгж хувиар бууцээ.

Банк бус санхүүгийн байгууллагуудын<sup>5</sup> нийт зээлийн өрийн үлдэгдэл нь 2010 оны эцсийн байдлаар 63.8 тэрбум төгрөг байв. Нийт санхүүгийн байгууллагуудаас эдийн засагт оруулсан **санхүүжилт 4037.7 тэрбум төгрөг** байлаа.




## Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2011 оны 4 дүгээр сард 0.9 нэгж хувиар өсч жилийн 10.95 хувьтай болов. Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү<sup>6</sup> өмнөх сарынхаас 0.6 нэгж хувиар өсч жилийн 16.4 хувь болсон бол гадаад валютынх 0.1 нэгж хувиар буурч жилийн 12.9 хувь болжээ. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү сүүлийн саруудад тогтвортой байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 1.6 нэгж хувиар буурч жилийн 10.7 хувь болжээ. Гадаад валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх сарынхаас 0.2 нэгж хувиар буурч жилийн 4.8 хувь болсон байна. Харилцахын жигнэсэн дундаж хүүнүүд сүүлийн саруудад харьцангуй тогтвортой байв.

<sup>5</sup> Санхүүгийн байгууллагад банк болон бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллагаас гадна банк бус санхүүгийн байгууллага орно.

<sup>6</sup> Зарласан хүү.



### Мөнгөний зах

2011 оны 4 дүгээр сард банк хоорондын захын арилжаагаар нийт 435.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 11.38 хувь байлаа.

2011 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс 2011 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн хугацаанд банкууд дунджаар төгрөгийн заавал

байлгах нөөцөд 300.2 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 157.6 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 309.1 тэрбум төгрөг, валютын нөөцөд 197.9 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

### Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2011 оны 4 дүгээр сарын эцэст 1258.47 төгрөг болж, өмнөх сараас 63 төгрөгөөр суларч, өмнөх оны мөн үеэс 114 төгрөгөөр чангарсан байна. Тайлант сард төгрөгийн ам. доллартай харьцах дундаж ханш 1219.90 төгрөг байв.

**МОНГОЛБАНК**